



## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн орон тоог шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн орон тоог хавсралт ёсоор шинэчлэн баталж, 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

3. Орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан шаардах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд хуваарилахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Бямбадорж)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын 2022 оны А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.ЗАЯАБАЛ



151610995



Татварын ерөнхий газрын даргын  
2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн  
А/56 дугаар тушаалын хавсралт

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА НЭГЖ БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ  
ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ГАЗАР, ХЭЛТСИЙН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

| №            | Албан тушаалын нэр                                                                 | Ангилал,<br>ээрэглэл | Орон<br>тоо |
|--------------|------------------------------------------------------------------------------------|----------------------|-------------|
| <b>22</b>    | <b>Дундговь аймгийн татварын хэлтэс</b>                                            |                      | <b>35</b>   |
|              | Дарга                                                                              | T3-10                | 1           |
| <b>22.1.</b> | <b>Захиргаа, хуулийн тасаг</b>                                                     |                      | <b>8</b>    |
| 22.1.1       | Тасгийн дарга                                                                      | T3-7                 | 1           |
| 22.1.2       | Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн                                        | T3-5                 | 1           |
| 22.1.3       | Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч                                  | T3-6                 | 1           |
| 22.1.4       | Нягтлан бодогч                                                                     | T3-6                 | 1           |
| 22.1.5       | Сүлжээний инженер                                                                  | TY-7                 | 1           |
| 22.1.6       | Архив-бичиг хэргийн эрхлэгч                                                        | TY-5                 | 1           |
| 22.1.7       | Жолооч-слесарь                                                                     | TY-3                 | 1           |
| 22.1.8       | Нярав-үйлчлэгч                                                                     | TY-4                 | 1           |
| <b>22.2</b>  | <b>Бичил татвар төлөгчтэй харилцах тасаг</b>                                       |                      | <b>19</b>   |
| 22.2.1       | Тасгийн дарга                                                                      | T3-7                 | 1           |
| 22.2.2       | Татварын улсын байцаагч                                                            | T3-6                 | 3           |
| 22.2.3       | Орлогын хяналт, суутган тооцоолол, буцаан олголт хариуцсан татварын улсын байцаагч | T3-6                 | 1           |
| 22.2.4       | Сумын татварын улсын байцаагч                                                      | T3-6                 | 14          |
| <b>22.3</b>  | <b>Жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг</b>                                       |                      | <b>4</b>    |
| 22.3.1       | Тасгийн дарга                                                                      | T3-7                 | 1           |
| 22.3.2       | Татварын улсын байцаагч                                                            | T3-6                 | 2           |
| 22.3.3       | Орлогын хяналт, суутган тооцоолол, буцаан олголт хариуцсан татварын улсын байцаагч | T3-6                 | 1           |
| <b>22.4</b>  | <b>Татварын хяналт, шалгалтын тасаг</b>                                            |                      | <b>3</b>    |
| 22.4.1       | Тасгийн дарга                                                                      | T3-7                 | 1           |
| 22.4.2       | Татварын улсын байцаагч                                                            | T3-6                 | 2           |

---oOo---